

БАТЛАВ.

ҮСХорооны Тамгын газрын дарга
/Ч.Цэвэгдорж/



БАТЛАВ.

“Би Си Ай” ХХК-ийн
/Бест Колор Интернэшнл/
Захирал /Н.Алдар/



**“НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА-2018” НЭГДСЭН ҮР
ДҮНГИЙН БАГЦ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ ҮСХ/2019/002

2019 оны 06-р сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас:

ҮСХороо, түүнийг төлөөлж Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга А.Амарбал /цаашид Захиалагч гэх/,

Нөгөө талаас:

Бест Колор Интернэшнл ХХК, түүнийг төлөөлж ЗБМА-ны менежер А.Анударь /цаашид гүйцэтгэгч гэх, хамтад нь талууд гэх/ нар харилцан тохиролцож, Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь Захиалагчийн эх бэлтгэлийн дагуу стандарт, чанарын шаардлагыг бүрэн “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” нэгдсэн үр дүнгийн багц ажил хэвлэх захиалгыг хүлээн авч гүйцэтгэх, захиалагч нь ажил үйлчилгээний төлбөр төлөхтэй холбогдон гарсан харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээний баталгаажуулсан Хавсралт №1 (үнэ, төлбөр тооцоо, ажлын гүйцэтгэл) нь гэрээний салшгүй хэсэг байна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Ажил гүйцэтгэх хугацаа нь 2019 оны 06 сарын 03-ны өдрөөс 2019 оны 06 сарын 28-ны өдрийг хүртэл байна.
- 2.2 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх хугацааг хожимдуулсан тохиолдолд энэхүү гэрээний 6.2-т заасан хариуцлагыг хүлээнэ.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Ажил үйлчилгээг гүйцэтгэх нийт үнэ 37.250.000₮ (Гучин долсон сая хоёр зуун тавин мянга) - н төгрөг байна.
- 3.2 Гэрээнд заасан аливаа төлбөрийг гэрээний хугацаанд БестКолор Интернэшнл ХХК-н Голомт банкны 2201044083 тоот төгрөгийн данс руу шилжүүлнэ.

Хуудсыг баталгаажуулсан:

1 / 5

- 3.3 Бүтээгдэхүүний үнэд НӨАТ орсон байна. Талууд гэрээний хугацаанд Хавсралт-1-д заасан Бүтээгдэхүүний үнийг өөрчлөхгүй ба хатуу мөрдөж ажиллана.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Захиалагч нь Хавсралт №1-ийг үндэслэн, гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөрийг хийж, ажил үйлчилгээг гүйцэтгүүлнэ.
- 4.2 Захиалгаар хийлгэх хэвлэлтэй холбоотой мэдээллээр хангах үүрэгтэй.
- 4.3 Гүйцэтгэх ажлын чанарыг харилцан тохиролцож баталсан чанарын түвшинд /I хавсралт/ байлгахыг шаардах эрхтэй.
- 4.4 Захиалагч нь бүрэн батлагдсан загвар материалыг сонгон Гүйцэтгэгчид хүлээлгэн өгч гарын үсэг зурж баталгаажуулна.
- 4.5 Ажлын гүйцэтгэлийг тухай бүрд хянах, ажлын явцтай танилцаж, өөрийн саналаа нэмж оруулах, ажил дууссаны дараа ажлын акт, гүйцэтгэлээр хүлээн авах бөгөөд захиалгыг зөрчиж, дутуу, чанар, стандартын шаардлага хангаагүй ажлыг тогтоосон хугацаанд засах, гүйцээн хийхийг шаардах, уг шаардлагыг биелүүлэх хүртэл төлбөрийн шилжүүлгийг зогсоох эрхтэй.
- 4.6 Захиалагч талын захиалгын шаардлагыг бүрэн хангаагүй болон засаж гүйцэтгэх хугацааг хожимдуулсан тохиолдолд захиалагч нь төлбөрийг буцаан нэхэмжлэх, нэг талын санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1 Гүйцэтгэгч нь “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” нэгдсэн үр дүнгийн багц ажил хэвлэлийг, тоо ширхэгийн дагуу захиалагчид чанарын өндөр түвшинд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2 Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээг гүйцэтгэхдээ стандарт, шаардлагын дагуу хийж гүйцэтгэн, ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээлгэн өгнө.
- 5.3 Гүйцэтгэсэн ажлыг актаар хүлээлцэх үед гүйцэтгэгчийн буруугаас үүссэн аливаа гологдол, доголдлыг 3 хоногийн дотор өөрийн зардлаар дахин хийж гүйцэтгэнэ. /Гологдол гэдэг нь захиалагч талын сонгосон загвар, материал, хэвлэлтийн өнгө, захиалагчийн гарын үсэг зурж эцэслэн баталгаажуулсан эхээс өөр байх, батлагдсан загвараас зөрсөн бүтээгдэхүүнийг хэлнэ/
- 5.4 Гүйцэтгэгч нь захиалагчид ямар нэгэн хүндрэл чирэгдэл үүсгэхгүйгээр үйлчлэх үүрэгтэй бөгөөд захиалгат ажлын ачааллаас үл хамааран гэрээнд заасан хугацаандаа ажил үйлчилгээг хүлээлгэж өгөх, гүйцэтгэх явцад оруулах өөрчлөлтийг тухай бүр нь оруулах, хурдан шуурхай зохицуулах үүрэг хүлээнэ.
- 5.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй байх бөгөөд ажлыг туршлагатай чадварлаг ажилтнуудаас бүрдсэн баг хийж гүйцэтгэнэ.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1 Энэхүү гэрээний нөхцлийг зөрчсөнөөс аль нэг талд хохирол учирсан тохиолдолд нөгөө тал хохирлыг бүрэн барагдуулна. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал батална.
- 6.2 Гүйцэтгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг захиалагчид төлнө.
- 6.3 Захиалагч энэ Гэрээний 3.2-д заасан хугацаанд Бүтээгдэхүүний төлбөрийг Гүйцэтгэгчид төлөөгүй бол Захиалагч нь төлөөгүй төлбөрийн үнийн дүнгээс хоног тутамд 0,5% (тэг аравны тав) хувийн алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 6.4 Хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд талуудын аль нь ч энэхүү гэрээг байгуулсантай

холбоотойгоор олж авсан нөгөө талын нууц мэдээлэл, эсхүл техникийн, үйл ажиллагааны, удирдлага зохион байгуулалтын, санхүүгийн эсхүл бизнесийн мэдээллийг аливаа этгээдэд задруулах, эсхүл аливаа бусад зорилгоор өөртөө ашиглахыг хориглоно.

- 6.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талд албан ёсоор бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд талууд хариуцлага хүлээхгүй.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 7.1 Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий этгээд харилцан гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 7.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд хавсралт байдлаар тусгах бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 7.4 Энэ гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд эвийн журмаар шийдвэрлэх ба боломжгүй болсон тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.
- 7.5 Гэрээг 3 хувь үйлдэж тал тус бүр өөрт ногдох хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль, эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 7.6 Гүйцэтгэгчийн нэхэмжлэл, Ажил хүлээлцсэн акт зэрэг нь гэрээний хавсралт болох бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 7.7 Энэ гэрээнд заасан хугацааг ажлын хоногоор бодох бөгөөд Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга

..... / А.Амарбал /

Хаяг: Засгийн газрын III байр, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, ҮСХорооны байр 316 тоот
Утас: 9909 1338

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Би Си Ай” ХХК-ийн
/Бест Колор Интернэшнл/
ЗБМА-ны менежер


..... /А.Анударь/

Хаяг: СБД, Жамъян Гүний гудамж-16/1
Утас: 319032, 8009 9032
И-мэйл: bci@bci.mn

Ажил үйлчилгээний үнэ, төлбөр тооцоо

№	АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ		ТОО ШИРХЭГ	НЭГЖ ҮНЭ	НИЙТ ДҮН	
1	Баримтын хуудас /Монгол/	Хэмжээ:	A4	1500	₮ 1,550	₮ 2,325,000
		Нүүр:	32			
		Материал:	Хавтас: 250гр матт бүрэлт Хавчуурга: 128гр матт			
		Өнгө:	4+4			
		Нэмэлт:	Үдэх			
2	Баримтын хуудас /Монгол/	Хэмжээ:	A4	500	₮ 1,860	₮ 930,000
		Нүүр:	32			
		Материал:	Хавтас: 250гр матт бүрэлт Хавчуурга: 128гр матт			
		Өнгө:	4+4			
		Нэмэлт:	Үдэх			
3	Тайлангийн нэгтгэл /Монгол/	Хэмжээ:	A4	1000	₮ 19,780	₮19,780,000
		Нүүр:	700			
		Материал:	Хавтас: 250гр матт бүрэлт Хуудас: 80гр офсет			
		Өнгө:	4+4			
		Нуруу:	Оёх, халуун цавуугаар наах			
4	Тайлангийн нэгтгэл /Англи/	Хэмжээ:	A4	500	₮ 27,090	₮ 13,545,000
		Нүүр:	700			
		Материал:	Хавтас: 250гр матт бүрэлт Хуудас: 80гр офсет			
		Өнгө:	4+4			
		Нуруу:	Оёх, халуун цавуугаар наах			
5	Карматай хавтас	Хэмжээ:	A4	500	₮ 1,340	₮ 670,000
		Нүүр:	2			
		Материал:	300гр			
		Өнгө:	4+4			
		Нэмэлт:	Хутга, хэв даралт, стикер наалт			
				TOTAL	₮ 37,250,000	

/НӨАТ орсон үнэ болно./



Хуудсыг баталгаажуулсан:
4 / 5




ХЯНАЖ ЗӨВШӨӨРСӨН:

Захиалагчийг төлөөлж:

Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга

..... / А.Амарбал /




Хаяг: Засгийн газрын III байр, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, ҮСХорооны байр 316 тоот

Утас: 9909 1338

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Би Си Ай” ХХК-ийн
/Бест Колор Интернэшнл/
ЗБМА-ны дарга

..... /Б.Намчинсүрэн/



Хаяг: СБД, Жамъян Гүний гудамж-16/1

Утас: 319032, 80089032

И-мэйл: bci@bci.mn

“Би Си Ай” ХХК-ийн
/Бест Колор Интернэшнл/
ЗБМА-ны менежер

..... /А.Анударь/




Хаяг: СБД, Жамъян Гүний гудамж-16/1

Утас: 319032, 80099032

И-мэйл: bci@bci.mn

Хуудсыг баталгаажуулсан:

5 / 5



ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № 98

2019 оны 6 сарын 24 өдөр

Байгууллагын нэр: Үндэсний статистикийн хороо ҮСХ-нэмэлт санхүүжилт	Дансны дугаар	37,250,000.00
Регистрийн дугаар: 6097456	100900026401	
Хүлээн авагчийн нэр: Бест колор интернэшнл	Дансны дугаар	
Регистрийн дугаар: 2692392	404029726	
Хүлээн авагчийн банк: ХХБанк		
Мөнгөн дүн үсгээр: Гучин долоон сая хоёр зуун тавин мянган төгрөг 00 мөнгө	Ангилал	
Гүйлгээний утга: НҮТСудалгааны багц тайлан хэвлэх зардал	70405 - Албан ёсны статистик 80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал 210404-Ном, хэвлэл	

Хяналтын хуудас №: 98

Үндэслэх бичиг баримтын нэр		Он сар, дугаар	Төрийн сангийн тэмдэглэгээ
1	Батлагдсан төсөв	2019.04.10	✓
2	НҮТС-н үр дүнгийн багц ажил гүйцэтгэх гэрээ	2019.06.03/ҮСХ/2019/002	✓
3	Тендерийн баримт бичиг	2019.05.24	✓
4	Үнэлгээний хорооны зөвлөмж /Гэрээ байгуулах/	2019.06.02	✓
5	Үнэлгээний хорооны хурлын эмгэг	2019.06.02/№03	✓
6	Үнэлгээний хороо байгуулах тухай тушаал	2019.05.21	✓
7	Нэхэмжлэх	2019.06.19/№01890	✓

Тамга

Дарга: /Ч.Цэвэгдорж/
Нягтлан бодогч: /Б.Оюундэлгэр/

Төрийн санд гүйлгээ хийсэн

..... оны сарын өдөр



НЭХЭМЖЛЭХ № 01890

Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6-р сарын 18-ны 171/111 тоот тушаалын хавсралт

НХМаягт Т-1

ТӨЛӨГЧ: ЧСХ-гоо

Бүртгэлийн дугаар: _____

Нэхэмжилсэн огноо: 2019.06.19

Төлбөр хийх огноо: _____

Нэхэмжлэгч: "Бест Колор Интернэшнл" ХХК

Бүртгэлийн дугаар: 2692392

Банкны нэр: ГОЛОМТ банк /2201044083-Т/

№	ЗХД	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1		ҮСХ / 2019 / 002 оом үрүн			37'250'000
2		мөнгө			
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					

Дүн үсгээр _____

(Тамга)

Дарга _____
Нягтлан бодогч _____

Дүн

НӨАТ

Нийт дүн

2

2

37'250'000